


АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



БАТЛАВ:

Г.ГАНБОЛД

2020 оны 2 сарын 03

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ОРОН НУТАГТ ХАМААРАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2020.02.03

Арвайхээр

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шаардагдах хөрөнгө	Хэрэгжилтэд хяналт тавих албан тушаалтан, хэрэгжүүлэх албан хаагч	Сум, агентлагт хамаарах заалт
1	2	3	4	5	6	7
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр						
1	1.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг тус тус аймаг орон нутагт хангуулах, төрийн байгууллагын удирдлагын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх.	1.1.1. Аймгийн Засаг даргаас Төсвийн шууд захирагч нартай байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцох.	1, 4 дүгээр улиралд	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг Ч.Удвал ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг Д.Мөнхцэцэг	-
		1.1.2. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр Сумдын Засаг даргын Тамгын газар, 21 агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН байгууллагын удирдах албан тушаалтнуудыг арга зүйгээр хангаж, нийт мэдүүлэг гаргагч нарын 2020 онд шинэчлэн гаргах хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, мэдээг тайланг АТГ-т хүргүүлэх.	1 дүгээр улиралд	-	Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Ганболд ХЭЗХ Д.Мөнхцэцэг	-

		1.1.3. АТҮХөтөлбөрийн төлөвлөгөөг 19 сум, 21 агентлагт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт, үр дүнг тооцох.	12 дугаар сард	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	-
		1.1.4. Аймгийн АТҮХөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дүнг Авлигатай тэмцэх газарт нь тайлагнах.	12 дугаар сард	-	Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Ганболд ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	-
Хоёр. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн төрийн байгууллагын нийтлэг үүрэг.						
2.1	2.1. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах.	2.1.1. Үйл ажиллагаандаа ашиглаж буй аймгийн албан ёсны цахим хуудас www.uvurkhangai.mn сайтад, хэлэлцэгдэж буй хууль, шийдвэрийн төслийг байршуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн зүгээс санал, хүсэлт илэрхийлэх бололцоог бүрдүүлэх.	Тухай бүр	Орон нутгийн төсвөөс	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ Н.Гуамарал	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.1.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд хариуцсан салбарын чиглэлээр хийгдсэн ажлаа тухай бүр цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	Тухай бүр	-	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.1.3. Авлигатай тэмцэх газраас АТҮХөтөлбөрийн биелэлтийг байгууллагын цахим хуудсанд нэвтрэн үнэлж, дүгнэх болсонтой холбогдуулан аймгийн ЗДТГазрын хэлтсүүд болон төрийн байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажлаа тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Тухай бүр	-	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга

2.2	2.2. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. Төрийн байгууллага Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах.	2.2.1. Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг 2020 оны төлөвлөгөө, иргэд болон хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан шаардлагатай гарын авлага, тараах материал бусад мэдээллийг бэлтгэн байршуулж, тогтмол шинэчлэх.	Тухай бүр	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.2.2. Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудаар үүссэн нөхцөл байдалтай уялдуулан онлайнаар сургалт мэдээлэл өгөх, гарын авлага, шторкыг олон нийтийн сүлжээгээр тараах.	Жилийн турш	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
2.3	2.3. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3. Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах.	2.3.1. Төрийн хяналт шалтгалтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах.	Тухай бүр	-	-	МХГазар, СХААлба
2.4	2.4. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх.	2.4.1. Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах.	Тухай бүр	-	СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр СТСХ Р.Цэрэндэжид	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.4.2. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох. (татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл) Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын хамт мэдээлэх.	Тухай бүр	-	СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр СТСХ Т.Эрдэнэсүрэн	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.4.3. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нийтэд мэдээлэх.	6 дугаар сард	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ О.Цэрэнчимэд	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга

		2.4.4. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хуваарилалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх, цахим хуудсанд байршуулж хэвших.	Тухай бүр	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ П.Мөнхзул	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
2.5	2.5. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5. Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах.	2.5.1. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжийг сайтад байршуулан олон нийтийг танилцах боломжоор хангах.	Жилдээ	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ Э.Бадамгэрэл	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.5.2. Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан, ил тод байдлыг хангаж ажиллах.	Тухай бүр	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ Э.Бадамгэрэл	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.5.3. "Аймгийн худалдаа, үйчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам", бүрдүүлэх материал, тусгай зөвшөөрөл олгосон иргэн, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулах.	Тухай бүр	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Б.Анхбилэг	-
		2.5.4. Эрүүл мэнд болон боловсролын салбарын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбогдох хууль, журам болон тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, олгосон тусгай зөвшөөрөл зэргийг тус тус сайтад байршуулж, нийтэд мэдээлэх.	Тухай бүр	-	НБХ-ийн дарга Б.Сайнжаргал НБХ С.Долгорсүрэн Р.Наранцэцэг	-

		2.5.5. Уул уурхай, байгаль орчин, газрын харилцааны салбарт олгогдож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой хууль, журам болон тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, олгосон тусгай зөвшөөрөл зэргийг тус тус сайтад байршуулж, нийтэд мэдээлэх.	Тухай бүр	-	ХОХБТХ-ийн дарга Г.Баясгалан ХОХБТХ С.Ганчимэг	-
2.6	2.6. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх.	2.6.1. (Аймгийн Засаг даргын захирамжийн нууцад хамааруулснаас бусад) болон бусад төрийн байгууллага удирдлагаас гаргасан шийдвэрийг байгууллагын цахим хуудаст байршуулж, нийтэд ил тод мэдээлэх.	Сар бүр	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Б.Анхбилэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.6.2. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт) дүрэм, журам, заавар болон төлбөрт үйлчилгээний жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах.	Тухай бүр	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ Н.Гуамарал	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
2.7	2.7. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.	2.7.1. Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл шуурхай хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх. (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)	Жилдээ	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг, ТЗУХ П.Мөнхзул, Л.Долгормаа	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
2.8	2.8. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага,	2.8.1 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, хугацаатай албан бичгийн биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлэх, зөвлөмжтэй холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Тухай бүр	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д. Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга

	шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.	2.8.2. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл болон хууль, журмын хүрээнд хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн албан бичгийн биелэлтийг тус тус шийдвэрлэн хугацаанд нь хүргүүлэх.	Тухай бүр	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
2.9	2.9. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчилнө.	2.9.1. Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу хянаж, хүчингүй болгох буюу өөрчилнө.	Тухай бүр	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д. Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.9.2. Сумдын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын даргын тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянах, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг хүчингүй болгуулах болон аймгийн Засаг даргын захирамжаар тус тус хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэх.	Жилдээ	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг Б.Анхбилэг З.Нацагням	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
2.10	2.10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах.	2.10.1. Хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах 13 төрлийн хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарч, албан тушаалтны ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалтанд зөвлөмж чиглэл хүргүүлж ажиллах.	Жилдээ	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		2.10.2. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг /шинэчлэн болон шинээр томилогдсон албан тушаалтнуудын/ үнэн зөв, хуульд заасан хугацаанд гаргуулах, бүртгэх, хянах, үйл ажиллагаа зохион байгуулах.	Жилдээ	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга

		2.10.3. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, цахим системд бүртгэх.	Тухай бүр	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
<p>Гурав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн аймаг, орон нутагт хамаарах 25 заалтын хүрээнд (Сум, агентлагт хамаарах) Зорилт 1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх.</p>						
3.1	3.1. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх.	3.1.1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх.	Тухай бүр	-	Аймгийн ЗДТГазрын дарга Ц.Ганболд ТЗУХ-ийн Э.Бадамгэрэл	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.1.2. Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох.	Тухай бүр	-	ТЗУХ Э.Батадгэрэл ХЭЗХ Д.Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.1.3. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн баримтад хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн тогтоол, дүгнэлтийг хавсаргах.	Тухай бүр	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д. Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.1.4. Төрийн жинхэнэ албан тушаалаас төрийн жинхэнэ албаны нөөцөд байх үндэслэлээр түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох.	Тухай бүр	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ Э.Бадамгэрэл	-
3.2	3.2.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, нийтийн албан тушаалтныг давтан	3.2.1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах.	Жилдээ	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг Э.Бадамгэрэл ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг З.Нацагням	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга

	сургах боломжийг бүрдүүлэх.	3.2.2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.	Жилдээ	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг Э.Бадамгэрэл ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг З.Нацагням	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.2.3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах.	Жилдээ	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д. Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
3.3	3.3. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	3.3.1. Төрийн байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх.	Жилдээ	-	ХЭЗХ А.Отгонцэцэг Д. Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.3.2. Төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.	Жилдээ	-	ХШУДАХ-ийн дарга Т.Үржинпүрэв Л.Ишханд	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
Зорилт 2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх.						
3.4	3.4. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.	3.4.1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.	Жилдээ	Сум, байгууллагын төсвөөс	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ, Ч.Батсуурь	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
3.5	3.5. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх.	3.5.1. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох.	Жилдээ	-	-	Мэргэжлийн хяналтын газар, СХААлба

3.6	3.6.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.	3.6.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх.	Жилдээ	Орон нутгийн төсөв	ХШУДАХ-ийн дарга Т.Үржинпүрэв Л.Ишханд	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.6.2. Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	Жилдээ	Орон нутгийн төсөв	ХШУДАХ-ийн дарга Т.Үржинпүрэв Л.Ишханд	-
		3.6.3. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх.	Жилдээ	-	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ Ч.Батсуурь	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
Зорилт 3.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.						
3.7	3.7. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх.	3.7.1. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.	-	-	СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр СТСХ Ц.Идэрсайхан	Сумдын ЗДТГазар
		3.7.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийн ил тод байдлын үнэлгээг хийж, холбогдох журам, дүрэмд өөрчлөлт оруулсан байх.	-	-	СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр СТСХ Ц.Идэрсайхан	Сумдын ЗДТГазар
3.8	3.8. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлага тооцох, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын	3.8.1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах.	Жилдээ	-	СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр СТСХ Р.Цэрэндэжид	Сумдын ЗДТГазар
		3.8.2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх.	Тухай бүр	-	СТСХ-ийн дарга Д.Нэмэхбаяр СТСХ Р.Цэрэндэжид	Сумдын ЗДТГазар

	дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.	3.8.3. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас төрийн (захиргааны) байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх.	Тухай бүр	-	СТСХ Д.Нэмэхбаяр ХЭЗХ А.Отгонцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
Зорилт 4.Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх.						
3.9	Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх.	3.9.1. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаашид тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж хэвшүүлэх.	Тухай бүр	-	ХОХБТХ-ийн дарга Г.Баясгалан ХОХБТХ Н.Осоржин	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.9.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах.	Тухай бүр	-	ХОХБТХ-ийн дарга Г.Баясгалан ХОХБТХ Н.Осоржин	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.9.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	Тухай бүр	-	ХОХБТХ-ийн дарга Г.Баясгалан ХОХБТХ Н.Осоржин	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
Зорилт 6. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.						
3.10	Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	3.10.1. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр өрсөлдөгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, ёс суртахуунтай, өрсөлдөөнт орчин бүхий бизнесийг дэмжин хөгжүүлэх.	Жилдээ	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ З.Нацагням ХОХБТХ-ийн дарга Г.Баясгалан, Н.Дулам	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
Зорилт 7.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх.						

3.11	3.11.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.	3.11.1.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлж, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.	Жилдээ	Сум, байгууллагын төсвөөс	ТЗУХ-ийн дарга Н.Энхцэцэг ТЗУХ Ч.Батсуурь	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
Зорилт 10. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх.						
3.12	3.12. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.	3.12.1.Төрийн байгууллагууд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, АТҮХөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах.	Жилдээ	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д. Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга
		3.12.2. Авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах, хамтарч ажиллах.	Жилдээ	-	ХЭЗХ-ийн дарга А.Отгонцэцэг ХЭЗХ Д.Мөнхцэцэг	Сумдын ЗДТГазар, агентлагийн дарга

-ооо-